



**НИЙСЛЭЛИЙН  
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 05 сарын 08 өдөр

Дугаар A/19

Улаанбаатар хот

**Хөл бөмбөгийн тэмцээн  
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Хөл бөмбөгийн тэмцээн зохион байгуулах тухай” А/483 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4 дэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гүйлтийн спортыг хөгжүүлэх, нийслэл хотоо дэлхийн улс орнуудад сурталчлах, гүйлтээр хичээллэгч, сонирхогч иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор “Нийслэлийн иргэдийн дунд хөл бөмбөгийн “Улаанбаатар цом” тэмцээнийг 2024 оны 05 дугаар сарын 20-26-ны өдрүүдэд, Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын дунд зохион байгуулагдах хөл бөмбөгийн “Мөрөөдлийн гоол” тэмцээнийг 2024 оны 05 дугаар сарын 06-15-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 30,462,000 (гучин сая дөрвөн жаран хоёр мянган) төгрөгийг “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ”-ний зардлаас гаргахыг нягтлан бодогч (П.Ариунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Спорт, нийтийн биеийн тамирын хэлтэс (С.Саранцэцэг)-т үүрэг болгосугай.



Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын  
 даргын 2024 оны ... дугаар сарын ...-ны  
 едрийн ... дүгээр тушаалын хавсралт



ХӨЛ БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭН  
 ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨСӨВ

| №                                       | Зардлын нэр               |          | Тоо ширхэг     | Нэг бүрийн үнэ (төг) | Нийт дүн (төг) |
|---|---------------------------|----------|----------------|----------------------|----------------|
| Хөл бөмбөгийн "Улаанбаатар цом" тэмцээн |                           |          |                |                      |                |
| 1.1                                     | Багийн шагнал             | 1-р байр | 1              | -                    | 1,000,000      |
| 1.2                                     |                           | 2-р байр | 1              | -                    | 800,000        |
| 1.3                                     |                           | 3-р байр | 1              | -                    | 500,000        |
| 1.4                                     | Аваргын цом               |          | 1              | 150,000              | 150,000        |
| 1.5                                     | Медаль                    |          | 48 ш           | 20,000               | 960,000        |
| 1.6                                     | Шилдгүүдийн тусгай шагнал |          | 3              | 100,000              | 300,000        |
| 1.7                                     | Шилдгүүдийн цом           |          | 3              | 80,000               | 240,000        |
| 1.8                                     | Өргөмжлөл, жааз           |          | 6              | 15,000               | 90,000         |
| 1.9                                     | Батламж                   |          | 48 ш           | 9,000                | 432,000        |
| 1.10                                    | Шүүгчдийн ажлын зардал    |          | 10x8 өдөр      | 80,000               | 6,400,000      |
| 1.11                                    | Эмчийн цалин              |          | 1x8 өдөр       | 50,000               | 400,000        |
| 1.12                                    | Карказ, чимэглэл          |          | 1              | 1,500,000            | 1,500,000      |
| 1.13                                    | Хулдаасан хэвлэл          |          | 40м2           | 12,500               | 500,000        |
| Дүн                                     |                           |          |                |                      | 13,272,000     |
| Хөл бөмбөгийн "Мөрөөдлийн гоол" тэмцээн |                           |          |                |                      |                |
| 2.1                                     | Багийн шагнал             | 1-р байр | 6              | 400,000              | 2,400,000      |
|   |                           | 2-р байр | 6              | 300,000              | 1,800,000      |
|   |                           | 3-р байр | 6              | 200,000              | 1,200,000      |
| 2.2                                     | Өргөмжлөл, жааз           |          | 18 ш           | 15,000               | 270,000        |
| 2.3                                     | Медаль                    |          | 288 ш          | 20,000               | 5,760,000      |
| 2.4                                     | Шүүгчдийн ажлын зардал    |          | 9 хүн x 8 өдөр | 80,000               | 5,760,000      |
| Дүн                                     |                           |          |                |                      | 17,190,000     |
| Нийт дүн                                |                           |          |                |                      | 30,462,000     |